

ХЭЛНИЙ СОЁЛ СУДЛАЛ НЬ МОНГОЛ СУДЛАЛЫН ШИНЭ
ПАРАДИГМ МӨН^{1,2}

Ж.Баянсан³

Түлхүүр үг: *хэл, сэтгэхүй (хэл-сэтгэхүй), сэтгэлгээ(хэл-сэтгэлгээ), үндэстний сэтгэлгээ, харилцаа, соёл(харилцаа-соёл), хэлний тэмдэг, соёлын тэмдэг(хэл-соёл), тогтвортой хэллэг, сэтгэлгээний тогтвортой хэвшинж, жишиг хэмжүүр, гадаад хэл сурах-сургах*

Энэ өгүүллийн гол санаа бол хэл-сэтгэхүй, хэл-сэтгэлгээ, хэл-харилцаа, хэл-соёлын харилцан хамаарлыг судлан тайлбарлах аргазүйн зарим асуудлыг хөндөхөд хамаатай юм.

Учир нь төрөлх хэлнийхээ зарим хэлцийн утгыг танин мэдэхүй, уламжлалт соёлын мэдлэг чадварын үүднээс тайлбарлахдаа бид хүч мөхөсдөх нь бий. Ийм учраас “оргүйгээс охинтой нь дээр” гэсэн хэллэгийг *монгол хүн охин хүүхэддээ төдий л дургүй байдгийг илэрхийлсэн утгатай болов уу?* гэх буюу “зээгээр үр хийдэггүй, зээрээр мал хийдэггүй” гэсэн хэллэг дээрхтэй утгын холбоотой юу? гэхэд мэгдэн тээнэгэлзэх том хүн ч бидний дунд цөөнгүйг нуултгүй.

Ялангуяа гадаад хэлийг сурч судлахын цагт энэ асуудал ихээхэн чухал учир холбогдолтой болж байна. Аливаа хэлийг сурч эзэмших гэдэг бол хэн бүхний мэдээжээр, тухайн хэлний наад зах нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг үгийн сангийн нөөцтэй байхын хамт дуудлагын хэм хэмжээ, хэлзүйн дүрэм загварыг ягштал баримталж сурах ёстой нь ойлгомжтой асуудал билээ. Гадаад хэлийг зааж сургах талаар олон арван жил хуримтлуулсан туршлага мэдлэг, сургалтын арга зүй ч энэ шаардлагыг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч ирсэн нь илэрхий байдаг.

Гэвч өдгөө хүртэл судалгааны хүрээнд зохих байраа эзэлж чадаагүй, тийм ч учраас сургалтанд ч нэвтрэх боломжгүй үлдсээр ирсэн нэг чухал асуудал бол үндэстний хэл ба тэдний соёлын харилцан хамаарлын тухай асуудал юм. Уг асуудлыг өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас эхлэн Structural anthropology, Social anthropology, Cultural anthropology, Linguoculturology, Ethnolinguistics, Ethnopsycholinguistics зэрэг

¹ Энэ өгүүллийг бичихдээ 2007 оны 10 дугаар сарын 19-20-нд Бээжинд Бээжингийн их сургууль, Сеүлийн их сургуультай хамтран “Солонгосын утга зохиол судлал”-аар зохион явуулсан Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан “Үндэстний сэтгэлгээний онцлогийн үүднээс хэлний илэрхийллийн утгыг тайлах асуудалд” илтгэл.

² 2009 оны 8 дугаар сарын 24-26-нд Улаанбаатарт болсон “Монгол туургатны эрт ба эдүгээ” Олон улсын эрдэм шинжилгээний III чуулганд хэлэлцүүлсэн “Хэлний судлалын шинэ парадигмын зарим асуудал” илтгэлд суурилсныг тэмдэглэе.

³ Доктор, профессор. МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Хүмүүнлигийн ухааны салаа салбарт юмуу, эсвэл тэдгээрийн уулзвар дээр судлан тайлбарлах болоод байна. Энэ бол уг асуудлын талаар судалгааны шинэ парадигма үүсэх шаардлагатай болсны гэрч юм. Орчин үеийн өрнө дахины гүн ухааны зарим чиглэл, тухайлбал Hermeneutics болон Transcendent чиглэлийнхний үзэл баримтлалын зарим хэсэг нь уг парадигмад хамаатай болж ирсэн нь санамсаргүй зүйл биш ажээ.

Энэчилэн гадаад хэлийг зааж сургахдаа “гадаад хэл, соёлыг аль алины нь тэгш төлөвшүүлэх арга замыг” (“second language and cultural acquisition”) (Chang Zongling 2005:233) эрж олох, “соёлыг цогцлоох үрийг суулгаж өгөх” (cultivation of “cultural creativity”) (Li Zuo Ven, Zheng Zhao Hong 2005:148-150) нь зайлшгүй болж байна.

Эдгээр үзэл баримтлалын гол санаа нь ялангуяа ямар нэг гадаад хэлийг сурч эзэмшинэ гэдэг бол тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстэн угсаатны ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал буюу сэтгэлгээний онцлог(Баянсан 2002)-ий нь зөв таньж ойлгоод улмаар түүнийг өөрийн унаган соёл, сэтгэлгээний онцлогтой харьцуулж, нийтлэг ба ялгаатай талы нь зөв илэрхийлж харилцах арга ухааныг сурч эзэмших учиртай гэдгийг онцолсон агуулгатай байна. Гэтэл энэ арга зарчмыг зөв ойлгох, зөв хэрэглэсэн аргазүйн дагуу судалгаа шинжилгээ явуулан үр дүнгий нь сургалт боловсролд нэвтрүүлэх ажил зайлшгүй чухал болох нь ойлгомжтой байдаг.

Ялангуяа харилцаж байгаа хоёр үндэстний соёлын ялгаа хэчнээн их байх тусам түүнийг зөв уялдуулж эзэмших арга зам нарийн төвөгтэй (Chang 2005: 228-233) болдог ажээ. Гэвч хэл, соёлын иймэрхүү ялгаатай байдлыг давж туулснаар тухай хүний мэдлэг ухаан арвижиж, сэтгэлгээний цар хүрээ өргөждөг учраас энэ үйл ажиллагаа бол хүний танин мэдэхүйг хөгжүүлэх ач холбогдолтойг мартаж болохгүй юм.

Нөгөөтээгүүр, орчин үед хүний хэлийг орчуулахад цахим төхөөрөмжийг дуулгавартай болгож эзэмшихсэн гэсэн хүсэл тэмүүлэл эрчимжиж байна. Энэ асуудлыг нэлээд төгс төгөлдөр шийдэж чадах нэг үндэс нь хэлний илэрхийллийн хэлбэрийн болон агуулгын үндсэн хэв маягийн хамгийн зохистой харьцаа боломжийг олж нээхээс эхлэх ёстой нь тодорхой байдаг. Аливаа хэлний янз бүрийн нэгжүүдийн бүтцийн зохистой шүтэлцээ, зүй тогтлыг одоо бараг олж чадсан бол харин агуулгынх нь энэ шүтэлцээ, зүй тогтлын олон зүйл бүрхэг бүдэг, илчилж нээхэд ээдрээтэй хэвээр байна. Энэ нь нэг талаас, хэлийг үүсгэн цогцлоогч хүний хүчин зүйл, нөгөө талаас, хүний танин мэдэхүй, сэтгэхүйг нээгдүүлэгч хэлний хүчин зүйлийн шалтгаант хамаарлыг бүрэн судлан тайлбарлаагүй байсантай холбоотой юм шиг байна. Дээрх тэмдэглэлийн сүүлийн хэсэгт хамаарах асуудал бол үндэстний сэтгэлгээний хэв маяг, “соёлын тэмдэг”-ийн үүрэг бүхий хэлний тогтвортой нэгжүүд хоёрын хамаарлыг нээж гаргахтай холбоотой учраас нарийн төвөгтэй, ээдрээтэй зүйл байж, хорьдугаар зууны хоёрдугаар хагасаас эхлэн хэлшинжлэлч, утга соёл судлаач төдийгүй, сэтгэл судлалч, хүн судлалч, угсаатан судлалч, соёл судлалч, гүн ухаантан нарын анхаарал сонирхлыг татах болсон байна.

Хүн төрөлхтөн хоорондоо харилцах олон зүйлийн арга, хэлбэрийг боловсруулан эзэмшиж ирсэн боловч хэлж харилцахаас илүү төгс төгөлдөр харилцааны арга хэлбэр үгүй мэт. Тэгвэл харилцахуй, соёл хоёрыг бас ангид авч хэлэлцэх нь харьцангуй асуудал болно (Samovar 2005, chf., II). Тэрчлэн хэл бол соёлын нэг зүйл болохын хувьд зайлшгүй нягт уялдаа хамааралтай байх нь ойлгомжтой боловч бас тус бүр өөр өөр мөнчнээр гэдгийг санах хэрэгтэй. Учир нь хэлний тэмдэг, хэлний илэрхийлэл болгон соёлын учир холбогдолтой байдаг гэж хялбарчлан ойлгож болохгүй. Ингэхлээр хэлний

ямар тэмдэг, ямар үед “соёлын тэмдэг” (Телия 1996) болдог вэ гэдгийг тусгайлан авч үзэх ёстой болно.

Соёл гэж юуг хэлэх бэ? гэдэг тухай хэдэн арван тодорхойлолт байдаг ч гэсэн хэрэв “хүнд байдаг хүнлиг зүйл болгоныг соёл” (Телия; мөн тэнд) гэвэл түүнд хамааралгүй үлдэх зүйл ч ховор байх нь илэрхий байна.

Нэг тодорхой үндэстэн угсаатны тухайд тэдний уламжлалт оюуны соёлын мөн чанар нь тэдний сэтгэлгээний тогтвортой хэв шинж юм. Сэтгэлгээний тогтвортой хэв шинж нь юм үзэгдэл, үйл явдал, шинж чанарыг *сайн-муу, сайхан-муухай, хэрэгтэй-хэрэггүй, таатай-таагүй, хүсүүштэй-хүсэшгүй, жирийн-жигтэй* гэх зэрэг эсрэгцсэн айд харгалзуулан үнэлж хэвшүүлсэн дадхал зуршил гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл, үнэлэмж (Value) бол үндэстний сэтгэлгээний онцлогийг тодорхойлох хамгийн гол шинж, үндсэн шалгуур нь юм.

Үнэлэмжийг үүсгэхдээ янз бүрийн жишиг хэмжүүр (Etalon)-ийг тогтоон ашигласан байдаг. Ингэхлээр эдгээр жишиг хэмжүүр болон түүгээр үүтгэгдэх үнэлэмжийн агуулга нь тухайн үндэстний эртнээс нааш бүтээн уламжилж ирсэн эдийн ба оюуны соёлын мөнчлал болж, хэлний тогтвортой нэгжүүдээр илэрч байдаг зүй тогтолтой ажээ.

Хэлний тогтвортой нэгж гэдэгт зүйр цэцэн үг зэрэг хэвшмэл хэллэгийн зүйл, бэсрэг хэллэг буюу нэр-үйлийн задлаг хам бүтэц, өвөрмөц хэллэг, оньсого тааврыг багтаан үзэж байна. Эдгээр нь дангаараа байж, харилцааны тодорхой орчин нөхцөлд бэлэн зэлнээрээ хэрэглэгдэж байхаас гадна ардын үлгэр тууль, ерөөл магтаал, дуу шүлэг, домог туулийн дотор ч амьжиж, биежсэн байдаг. Тэр болгон нь цаг цагийн уран зохиол, сонин сэтгүүлийн нийтлэл зэрэг бичгийн зохиолын уран яруу илэрхийлэх найруулгын ур маягийнх нь үндсэн хэрэглүүр болж байдаг. Ийм учраас эдгээр нь үндэстний сэтгэлгээний хэв маягийн уламжлал, шинэчлэлийн онцлог байдлыг таниулах гол хэрэглүүр болно.

Үндэстний сэтгэлгээний агуулга, бүтцийг тодорхойлох хэлний бус хүчин зүйлүүд гэвэл;

- тухайн үндэстний аж төрж ирсэн нутаг газрын байгалийн юмсын тогтоц байдал, өөрөөр хэлбэл, цаг уурын онцлог, уул ус, ой мод, хөрс шороо, тэнд ургадаг өвс ургамал, амьдардаг араатан жигүүртний төрөл зүйл;
- тухайн үндэстний эртнээс нааш эрхэлж ирсэн уламжлалт аж ахуй, аж төрөх ёсны онцлог, шашин шүтлэг, ёс заншлын бүх зүйл;
- Тухайн ард түмний эртнээс нааш бүтээн цогцлуулж ирсэн уламжлалт эд өлгийн зүйл цөм шууд хамаатай байж, тэр хэлнийх нь тогтвортой хэллэгийн агуулга, утга учрын үндэс болж байдаг ажээ.

Ийм учраас үндэстний хэлийг сурч судална гэдэг бол тэр үндэстний эдийн болон оюун билгийн соёлыг таньж эзэмшинэ гэсэн үг гэдгийн учир ийм байна.

Дээр тэмдэглэсэн бүх зүйл тогтвортой хэллэгт ямар нэг байдлаар заавал тусч илэрсэн байдаг.

Жишээлбэл,

Монгол хэлний “хаврын тэнгэр шиг ааштай хүн” гэдгийн “хаврын тэнгэр шиг” гэдэг нь олон ааштайг илэрхийлсэн утгатай гэдгийг мэдэх нь монгол хэл сурч эзэмших зөвхөн эхний нэг төвшинд л хангалттай мэдээлэл байж болох юм. Гэтэл монгол орны хаврын цаг уурын байдал, тэр үед мал хуйгаа адуулж амьдрахад ямархуу байдгийг эс мэдэх аваас “хүнийг хүн гэнэ”, “амьтныг амьтан гэнэ” гэснээс цаашгүй зүйл болно.

Түүнчлэн “яаравч явган бүү суу” гэсэн сургаал үгийг энэ л утгынх нь дагуу ойлгож мэдээд “яарч байсандаа болоод чухам л явган суумаар байсан ч тэгж болохгүй юм байна” гэж мэдэхэд буруу биш боловч, нас барсан хүнийг оршуулах газрыг сонгож шинжихдээ уг газрын энд тэнд нь очиж ийн сууж шинжилдэг арга ёстойгоос үүдэж энэ тогтвортой хэллэг ийм цээр ёсны илэрхийлэл болсныг үндэстний соёл-хэл-үндэстний сэтгэлгээний харилцан хамаарлын үүднээс таньж мэдэх, тайлбарлан ойлгох, ойлгуулах асуудал бас нэг өөр хэрэг юм.

Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд Дамба, Цамба гэдэг хоёр хархүү ярилцаж байхдаа нэг нь нөгөөгөөсөө: “-Чи цавын будаа идэх үү, цавуутай толгой тэврэх үү?” гэж асуудгийн утгыг “эхнэр авах уу, лам болох уу?” гэсэн утгатай гэдгийг мэдэхэд буруу биш нь мэдээж, харин уг утгыг цааш нь лавшруулсхийгээд: “бурхны номыг үзэхээр сахил хүртэж (эхнэр авахгүй), сүм хийдэд шавилан сууж “хар хүн” болох уу?, эсвэл эхнэр авч (үсээ цавуудсан, эсэхээр нь бүсгүй хүнийг эрд гарсан, эсэхийг нь мэддэг уламжлал байжээ) “хар болох” уу? гэсэн утгатай гэдгийг мэдэх явдал бас нэг өөр хэрэг болно.

Мөн “зээрээр мал хийдэггүй, зээгээр үр хийдэггүй”, “оргүйгээс охинтой нь дээр” гэсэн хэллэг нь охин үр бол хүний эхнэр болж, төрүүлсэн эцэг эхээс нь өөр хүний голомтыг залгах үрийг төрүүлэх хувь тавилантайг мэдрүүлсэн утгатай байдаг нь монголчуудын “үрээр хүн хийж, үрээгээр морь хийж” ирсэн уламжалт соёл, ёс заншлаас үүтгэлтэйг эс ухаад, шууд утгаар нь бодож, монгол хүн охин хүүхэддээ хайргүй байдаг юм шиг ойлговол ноцтой алдаа болох юм.

Энэ мэтчилэн амьтан, мал адгуусны ааш араншин, авир төрхийг таньж мэдсэн туршлага мэдлэгээ хүний ааш зангийн онцлог, дотоод сэтгэлийн байдлыг илэрхийлэх жишиг хэмжүүр (etalon) болгон хэрэглэдэг үг хэллэг монгол хэлэнд хэдэн зуу, мянгаар байдаг. Жишээлбэл;

Энэрч эргэх янзгүйг “хургаа голсон хонь малтай”;

Ижил олноосоо гэнэт салж одохыг “шилэрсэн ингэтэй”;

Тогтвор суурьшлаа алдахыг “өттэй ямаа/тэмээ, эсвэл яргуй хөөсөн ямаатай”;

Орох гарах газар оронгүй болж мухардахыг “үнсэнд хаясан хувалз/шалзтай”;

Эв найртай, зохицол нийцэмжтэйг “нуур нугас хоёртой”;

Дуулгавартай хүлцэнгүйг “дөрлүүлсэн бухтай”;

Дуулгаваргүй гөжүүд зөрүүдийг “дөргүй бухтай” тус тус үлгэрлэх буюу Харамчийг “нарийн, нарийндаа хатсан, хорголоо тоолсон, гарын алга дээш нь харуулж үзээгүй, гаднах нь гэртээ, гэртэх нь гэдсэндээ ороогүй, лонхонд унгаад нохойд зайл өгдөг” гэх мэтийн хэллэгүүд цөм малчин-нүүдэлчин монголчуудын уламжлалт аж төрөх ёс, ахуй соёлын онцлогоос үүдэлтэй байгааг мэдэж болно.

Ямар ч гадаад хэлийг эхлэн үзэж байгаа хүнд тэр хэл нь төрөлх хэлтэй нь адилдуу, сурахад төдий л төвөгтэй биш юм шиг санагддаг ажээ. Хэл сурч байгаа энэ үе шат бол зөвхөн тухайн хэлнүүдийн янз бүрийн төвшний нэгжүүдийн хэлбэр-загвар төдийхөнд орчиж байгаагийн илрэл болдог байна. Гэтэл лавшруулан гүнзгийрүүлж сурахын хэрээр хачирхалтай зүйл алхам тутам тулгарч, улам бүр хэцүү бэрх болж ирдэг нь үндэстний “соёлын тэмдэг” болсон хэлний илэрхийлэлтэй танилцаж эхэлж байгаагийн илрэл болдог байна.

Ийн үзвэл хэлийг сурах, судлах хоёр шат байна гэж бүдүүвчлэн хэлж болох юм. Нэг хэлийг сурч эзэмшсэн төвшин нь өдөр тутмын энгийн харилцааг залгуулах төдий байвал тухайн хэлний янз бүрийн тогтвортой хэллэгийн далдлагдмал утга санаа буюу

соёлынх нь учир холбогдлыг тэр болгон мэдэх албагүй, хэрэв хэзээ нэг цагт, хаа нэгтээ “энэ үгийг орчуулахад *нохой хорихгүй нь ээ*” гэсэн өгүүлбэртэй тааралдлаа гэж бодвол түүнд байгаа “*нохой хорихгүй*” гэдэг нь “*яаж ч чадахгүй, юу ч хийж чадахгүй, ямар ч хариу ирүү өгөхгүй*” гэсэн шиг утгатай гэдгийг л мэдэхэд бараг хангалттай байж болох юм.

Гэтэл тухайн үндэстний хэл бол тэдний соёл, сэтгэлгээний онцлогийнх нь илэрхийлэл байх ёстой гэдэг үүднээс хэлний асуудалд хандаж байгаа бол ер нь “*нохой хорих*” гэдэг үйл, нэрийн холбоо үг шууд утгаараа малчин монголчуудын ахуй амьдралын ямар байдлыг нэрлэж тэмдэглэсэн болохыг эхлээд мэдэх, улмаар тэр айлыг нохойгүйг нь лавтай мэдэж байгаа хэрнээ өөрийнхөө ирж байгааг мэдээлэх, мөн тэр сацуу, тэр айлын гэрт хүн байгаа эсэхийг мэдэх зорилгоор, гэрт дөхөж ирээд “*Нохойгоо хорь, оо!*” гэж дууддагийн учрыг мэдэх болно. Энэ мэтээр уламласаар байгаад “*нохой хорихгүй*” гэдэг хэллэг “*яаж ч чадахгүй, ямар ч хариу ирүүгүй*” гэсэн утгатай болсны учрыг мэдэж авах боломжтой болдог байна.

Ялангуяа уран зохиол, тэр тусмаа шүлэг найраг, мөн хэлний дүрслэх хэрэглүүрийг түгээмэл ашигладаг нийтлэл, найрууллын зүйлийг өөр хэлээр орчуулахын цагт хоёр өөр соёл-хэлтний нийтлэг ба ялгаатай онцлогийг зөв харгуулан оноох асуудал маш нарийн, хэцүү бэрх байдгийг төсөөлөхөд хэцүү биш билээ. Үүнд реали-ийг орчуулах, хэлц нэгжийг орчуулахын аль аль нь хамаатай болно.

И.А. Крыловын “Чоно хурга хоёр” үлгэрийг сурагчдаар жүжигчлэн тоглуулах болоход чонын дүрд нэг ч орос хүүхэд тоглох дургүй байсан бол харин киргиз хүүхэд болгон чонын дүрд тоглох дуртай байсан тухай Ю.М. Верещагин, В.Г.Костомаров нар номдоо өгүүлснийг И.Н. Горелов, К.Ф. Седов нар(2001:124):чоныг үзэх үзэл энэ хоёр соёл-хэлтэнд тэс өөр, киргизүүд ЧОНО гэдэг үгээр өдлөг болгоод тодорхойлон тоочуулах асуулгын хариу нь *ээлтэй сайн, догшин сүрлэг, хүчирхэг тэнхээтэй, эрэлхэг зоригтой, гоёмсог сайхан, овсгоотой сэргэлэн* гэх мэтээр сэтгэгцэнд нь эерэг үнэлэмж бүхий авалцуурууд тогтвортой хэв шинж болсон байдагтай холбон тайлбарласан байдаг.Мөн авалцуулан холбох аргаар А.А.Залевская-гийн хийсэн туршилт-судалгаагаар: ЦАГААН өнгийг туршилтад оролцсон оросуудын олонхи нь **цастай** холбосон бол узбекүүд **хөвөнтэй**, харин казакууд **сүүтэй** тус тус холбон хариулсан ажээ. Харин ЦЭНХЭР өнгийг туршилтад оролцогсодын зонхи нь **тэнгэртэй** холбосон байна. Гэвч ШАР өнгийг орос, украин, белорусуудын олонхи нь эхлээд **намрын навчтай** холбосон бол францууд **алт, өндөгний шартай**, америкчууд **цөцгийн тостой...** тус тус холбон хариулсан гэдэг (өмнөх зохиол, х123). Ийм төрлийн жишээ баримтыг түүвэрлэн тоочвол дуусахгүй мэт. Гэтэл монгол хүн иймэрхүү туршилтад ямар ямар хариу өгөх дадхалтайг зайлшгүй судлаж тодорхойлох хэрэгтэй болоод байна.

Үүнчилэн хоёр зүйл **маш адил** хэмээх санааг монгол хэл-соёлтон **ихэртэй**, оросынхоор **усны хоёр дусалтай**, харин английнхаар **вандуйн хоёр үртэй** адилтгадаг нь хэв шинжит үзэгдэл, баримт ажээ(Этнопсихоллингвистика. 1988:123).

Энэчилэн хятад хэлний “төмөр(шаазан) тахиа”, “шилэн муур”, “нохой, бөөс идээд хойд хөлий нь үлдээх” гэдэг зүйрлэл, хэллэг хүний ямар шинжийг илэрхийлж болохыг монгол соёл-хэлтнээс, монгол хэлний “хорголоо тоолох” хэллэгийн утгыг хятад соёл-хэлтнээс асуувал “харамч, харамлах” хэмээх багцалмал мэдлэгийн нэгэн илэрхийлэл ээ гэж шуудхан хариулж өгөх болов уу, үгүй болов уу. Мөн “Ванькагийн сураагүйг Иван Иванович мэдэх учиргүй” гэсэн орос хэллэг монголын “Хургандаа цадаагүй бол

төлгөндөө майлна” хэлэгтэй утга дүйнэ гэвэл тайлах учры нь үндэстнийх нь соёлын мэдлэгээс эрж хайхаас өөр гарцгүй болно.

Соёлжлын төлөв байдлыг Zhang Ailing(2005:52-4) ерөнхийд нь бодгальжсан соёл (individualistic culture), хамтажсан соёл(collectivist culture) гэсэн хоёр үндсэн хэв маягтай байна гэж тодорхойлжээ. Эхнийхэд нь америк маягийн соёл, сүүлчийнхэд нь хятадыг оролцуулан Ази, Африк, Өмнөд америк, Арлын олон улс үндэсний соёлжсон төлөв байдлыг авч үзсэн байна. Үүнийг нэг үндэс болговол Монголчууд хамтарч амьдрах, хамтач соёлын дэг хүрээнд хамрагдаж болно гэдгийг хэлэнд нь байдаг дараах илэрхийллийн утга санаатай холбон хэлж болох юм шиг санагдаж байна. Тухайлбал:

- Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг,
- Ганц хүн айл болдоггүй, ганц мод гал болдоггүй,
- Ганцаар идсэн гахай таргалдаггүй, олуулаа идсэн оготно турж үхдэггүй,
- Олзыг олуулаа гэх зэрэг хэллэгийн утга санаа нь энэ зүйлийг гэрчилч байна.

Энэчилэн “цөөн хүн хүртэхээрээ, олон хүн идэхээрээ”, “шөлөөр цадаж, төлөөр баяждаг”, “идээний бага нь амттай”, гэх буюу “далын хуудсыг далуулаа” гэдэг хэллэг ч үүнтэй холбож хэлэлцэх зүйл гэж бодож байна.

Түүнчилэн овоо дээр очиж арц хүж уугиулан сан тавьж, сацал өргөж байгаа хүн “олзын их нь надад, овооны их нь танд аа!” гэж шившин залбирдаг зэрэг нь хүний амьдрал, хувь заяа бол хэдийгээр тэр хүнд өөрт нь оногдсон хувь тавилан боловч, ганцхан өөрөө эрхшээж чадахгүй, бусдаас ч хамаатай, тэнгэрээс ч айлтгал, тохиолготой гэж үздэг учраас энэ хэллэгийн утгыг дээрхтэй хамаатай болгон тайлбарлаж болох юм.

Ийм учраас “хувиа бодож довоо шарлуулах”, “амиа хоохойлох”, “амиа бодох” нь хүний зан төлөвийн муу шинж гэж үздэг.

Бас нэг жишээ татвал,

Ганзага гэж юу вэ гэвэл, эмээлийн хавтас бүрийн өмнө хойд, талд бэхэлсэн нарийн сур. Чөдөр ногт юмуу, эсвэл ачаа бараа авч явахдаа түүгээр уяж бэхэлнэ гэсэн шиг товч тайлбар байх ёстой болно.

Гэтэл “ганзага нийлэх” гэдэг өвөрмөц хэллэг (idiom) ямар утгатай вэ? гэхлээр ямар нэг ажил үйл хийхэд санаа зорилго нэгтэй байх-ыг хэлнэ гэдэг. Монголыг судлах зорилгоор биш, монголоор ойр зуурын юм ярьж, харилцаж чаддаг болох гэж буй хүнд энэ л утгы нь мэдэхэд болохгүй юмгүй. Харин хэлийг тухайн үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдлын илэрхийлэл буюу тэдний эдүгээ хүртэл бүтээн уламжилж ирсэн эдийн ба оюуны соёлынх нь тайлал-дохио, тайлал-тэмдэг гэх үүднээс судалж байгаа бол дээр ишилсэн хэллэгээс гадна “ганзага хоосон”, “гуяа ганзгалах”, “толгойгоо ганзгалах”, “гар ахар, ганзага богино”, “ганзага мялайх”, “гары нь ганзганд, хөлий нь дөрөөнд хүргэх”, “ганзгыг” (хийморийг) нь ямаа хивсэн” гэх зэрэг хэллэгүүдийг нэг багц болгон тус бүрийнх нь хэрэглэгдэх орчин нөхцөл, түүндээ уялдсан утга санааг нь тайлбарласны дүнд “ганзага” гэдэг бол зүгээр нэг тоног хэрэгслийг ялган нэрлэсэн нэр төдий зүйл биш, морьтой монгол хүний тухайд ганзага нь олз омогтой, аз хийморьтой явж байна уу? Үгүй юу? гэдгийн бэлгэдэл утга санаа болгон ухаарч хэвшсэн зэргээр нүүдэлчин, малчин монголчуудад түүнтэй холбоотой өвөрмөц зан үйл, өвөрмөц үзэлт оршиж байдгийг мэдэх боломжтой болно.

Дүгнэлт

- Үндэстний хэл бол тэдний харилцааны чухал хэрэглүүр төдийгүй, тэдний уламжлалт эдийн болон оюуны соёлынх нь онцлогийн тусгал, илэрхийлэл болдог. Ийм үүрэгтэй илэрхийлэл нь тухайн хэлний хэшмэл хэллэг, өвөрмөц хэллэг, оньсого таавар, үлгэр домог, дуу шүлэг, ерөөл магтаал зэрэг ардын билиг зохиолоор уламжилж, орчин үеийн уран зохиолын бүх төрөл зүйл, сонин, нийтлэлийн найруулгад яруу илэрхийлэх, дүрслэх хэрэглүүр болон хэрэглэгддэг байна.

- Үндэстний сэтгэлгээ бол юм үзэгдлийг эерэг, сөргөөр эсрэгцүүлэн үнэлэхтэй холбоотой. Ингэж үнэлэхдээ тусгай жишиг хэмжүүрийг үүсгэж, шалгуур болгодог байна. Энэ жишиг хэмжүүр нь тухайн үндэстний эдийн болон оюуны уламжлалт соёлын зүйлийг илэрхийлсэн байдаг. Ингэхдээ уг үндэстэн шинээр таньж мэдсэн, ухаарч ойлгосон, шинээр бүтээж бий болгосон зүйл болгоныг адилтгах зүйрлэх аргаар илэрхийлэх үүрэгтэй байна. Ийм учраас сэтгэлгээ бол үндэстний шинжтэй, харин сэтгэхүй нь нийт хүн төрөлхтний шинжтэй зүйл гэж ялган ойлгож болно гэж үзэж байна.

- Хэлийг сурах хоёр шат байна гэж ерөнхийлөн хэлж болно. Хэрэв тухайн хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстний ертөнцийг үзэх үзэл ертөнцийг таньсан байдлын тусгал, сэтгэлгээнийх нь онцлогийн илэрхийлэл болдог гэх үүднээс хэлийг сурч байгаа бол судалгааны чиглэлтэй буюу эзэмших төвшинд зорьсон сургалт, үйл ажилллагаа гэж үзвэл зохино. Харин ойр зуурын харилцааг залгуулах төдий сурах нь тийм ч хэцүү бэрх биш, онцгой мэдлэг чадвар шаардах үйл ажиллагаа биш учраас “гадаад хэлийг сурах” гэдэг ойлголтыг ялгавартай авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

- Ер нь аливаа хэлийг сурч эзэмших гэдэг нь уг хэлийг төрөлх хэлээ болгосон үндэстний ертөнцийг үзэх үзэл, ертөнцийг таньсан байдал буюу юм үзэгдэл, үйл байдал, шинж чанарыг “сайн-муу”, “сайхан-муухай”, “хэрэгтэй-хэрэггүй”, “ашигтай-ашиггүй”, “тустай-тусгүй”, “хүсмээргүй-хүсүүштэй”, “таатай-таагүй” гэх мэт эсрэгцсэн айгаар үнэлж цэгнэх онцлогтой зайлшгүй шүтэлцээтэй хэмээн хандах ёстой гэж үзэж байна. Энэ бол хэлний зарим үзэгдэл баримтыг хэлшинжлэл, угсаатны судлал, сэтгэцийн хэлшинжлэл, соёлын ба нийгмийн хүн судлал зэрэг Хүмүүнлигийн ухаануудын уулзвар дээр шинжлэн тайлабарлах зайлшгүй нөхцөлдлөөс үүдсэн судалгааны шинэ парадигма-ыг бий болгож байна гэж үзүүштэй байна.

Ишилсэн номын гарчиг

Ж.Баянсан. (2002) *Соёл, хэл, Үндэстний сэтгэлгээ*, Улаанбаатар. Монгол улсын их сургуулийн хэвлэх үйлдвэр.

И.Н. Горелов, К.Ф. Седов. Основы психолингвистики. Москва. "Лабиринт", 2001

В.Н.Телия. Русская фразеология: Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. Москва, Школа "Языки Русской Культуры" 1996.

Этнопсихолингвистика. Москва, "Наука", 1988

Zhang Ailing. (2003) *Intercultural Communication*, Chu Ban She: Chong Ching Da She
Li Zuo Wen & Zheng Zhao Hong (2005) *Language and Culture*, Hebei University Press.

L. A. Samovar, R. E Porter & L. A. Stefani . (2005) *Communication between Cultures*, Foreign Language Teaching and Research Press, Brooks/Cole/Thomson Learning Asia.

Chang Zongling. (2005) *Cognitive Studies in Language & Culture*, Qingdao: China Ocean University Press

SUMMARY

It is necessary to explain the meaning of fixed word combination of language and culture owners' outlook. Fixed word combination has to be studied in connection with linguistics, culturology, psychology and philosophy. Today learners of Mongolian language or learners of foreign language should follow this trend.